



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2008 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 294

Улаанбаатар хот

**Гадаадад зээлээр суралцуулах,  
тушаалд өөрчлөлт оруулах тухай**

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам", шалгалтын комиссын дүн, захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нямсамбуу овогтой Батжаргалыг Монголбанкны захиалгаар АНУ-ын Калифорнийн Улсын их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Барсүрэн овогтой Баасандоржийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын захиалгаар Австрали Улсын Deakin их сургуулийн магистрантурт үндсэн хуулийн эрх зүйн чиглэлээр, Ганбат овогтой Нарантуяаг Хүний эрхийн үндэсний комиссын захиалгаар Австрали Улсын Мельбурний их сургуулийн магистрантурт олон улсын нийтийн эрх зүйн чиглэлээр, Баасанжав овогтой Гомбодоржийг Үйлдвэр, худалдааны яамны захиалгаар АНУ-ын Калифорнийн Улсын их сургуулийн магистрантурт мэдээллийн технологийн чиглэлээр, Гончигзэвэг овогтой Энхзулыг Үйлдвэр, худалдааны яамны захиалгаар АНУ-ын Калифорнийн Улсын их сургуулийн магистрантурт ашигт малтмалын эдийн засгийн менежментийн чиглэлээр, Бямбацэрэн овогтой Хосбаярыг Үндэсний статистикийн хорооны захиалгаар АНУ-ын Линкольн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Содномцэрэн овогтой Энхтөрийг Монголбанкны захиалгаар Австрали Улсын Үндэсний их сургуулийн магистрантурт төрийн бодлогын чиглэлээр, Оюунболд овогтой Ганчимэгийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар АНУ-ын Харвардын их сургуулийн магистрантурт удирдлагын чиглэлээр, Даваадорж овогтой Тэлмэнг Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын захиалгаар АНУ-ын Massachusetts технологийн сургуулийн магистрантурт мэдээллийн технологийн чиглэлээр, Ойдов овогтой Нарангэрэлийг Үйлдвэр, худалдааны яамны захиалгаар АНУ-ын Калифорнийн улсын их сургуулийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр, Бадам овогтой Алимааг Монголбанкны захиалгаар АНУ-ын Олон улсын америкийн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Жанцанноров овогтой Дамдинцэрэнг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Япон Улсын Токиогийн урлагийн их сургуульд урлагийн менежментийн чиглэлээр тус тус 2 жилийн

*Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам, шалгалтын комиссын дүн, захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:*

*2008.06.05  
Суралцагч  
АНУ Калифорни улс,  
Дасан их сургууль  
Магистрантурт  
Угс зэрэг аргачлалыг  
Ганбат нарантуяагт өөрчлөлт*


00 0001

хугацаагаар 2008-2009 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 417 дугаар тушаалын Нармандах овогтой Жамъянхүүтэй холбогдолтой хэсгийн "АНУ-ын Колорадогийн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр" гэснийг "Австрали улсын New South Wales их сургуулийн магистрантурт эрх зүйн чиглэлээр" гэж өөрчилсүгэй.

3. ОХУ-ын Санкт-Петербург хотын С.М.Кировын нэрэмжит Ойн техникийн улсын академийн докторантурт суралцаж буй Хижаба овогтой Ыханбай, ОХУ-ын Новосибирск хотын Анагаах ухааны их сургуулийн аспирантурт суралцаж буй Ядамсүрэн овогтой Энхтөр, ОХУ-ын Нефть, хийн их сургуулийн аспирантурт суралцаж буй Магсар овогтой Оюунтөгс нарын эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг зээлээр олгосугай.

4. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



*Н.Болормаа*

Н.БОЛОРМАА